



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 6/47

Хэрлэн сум

Г.Ариунхүүг түр орлон  
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.4, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн М.Дэлгэрзаяа нь жирэмсний болон амаржсаны амралтаа авсан тул Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж байгаа Гүрцэдэнгийн Ариунхүүг Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтний албан тушаалд 2022 оны 6 дугаар сарын 09-өөс эхлэн түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Г.Ариунхүүгийн цалинг ТЗ-5-2 шатлалаар тогтоож, үндсэн цалинг 680286 (зургаан зуун наян мянга хоёр зуун наян зургаан мянга) төгрөгөөр, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 15 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Г.Ариунхүүд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030310